



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 10 өдөр

Дугаар 1/405

Чингис хот

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх  
нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.5, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2014 оны “Журам батлах тухай” А-166, 2016 оны “Журманд өөрчлөлт оруулах тухай” А/24, 2020 оны “Ойгоос хуш модны самар бэлтгэж ашиглахыг бүсчлэн тогтоох тухай” А/577 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх “Хяналт шалгалт–2020” нэгдсэн арга хэмжээг 2020 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 10, 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 10, 01 дүгээр сарын 10-ны өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд 3 үе шаттайгаар зохион байгуулсугай.

2. Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч	Ж.Ганбаатар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Орлогч	П.Мөнхбаяр	Цагдаагийн газрын дэд дарга бөгөөд Эрүүгийн тасгийн дарга
Нарийн бичгийн дарга	Б.Нямхатан	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд:	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга
	А.Гантөмөр	Татварын хэлтсийн дарга
	Б.Сүнгээ	Мэргэжлийн хяналтын газрын дарга
	Б.Мөнхжаргал	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Б.Хашмаргад	Хан Хэнтийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга /зөвшилцсөнөөр/

231010476

2.

Б.Энхбат	Цагдаагийн газрын Экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч
М.Болд	Батширээт сумын Засаг дарга
Б.Эрдэнбаатар	Өмнөдэлгэр сумын Засаг дарга
Г.Мөнх-Оргил	“Хэнтий-шинэс” сум дундын ойн ангийн дарга
Ч.Ундармаа	“Батширээт” сум дундын ойн ангийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

3. Хуш модны самрыг Өмнөдэлгэр, Батширээт сумдад үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар, Хан Хэнтийн дархан цаазат газар, Цэнхэрмандал, Дэлгэрхаан сумдад ахуйн зориулалтаар бэлтгэж ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих үүрэг бүхий байнгын хяналтын цэгийг байгуулж, холбогдох албан тушаалтныг томилж ажиллуулахыг Цагдаагийн газар /Б.Батсайхан/, Онцгой байдлын газар /Ж.Эрдэнэбат/, Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Б.Нямхатан/, Хан Хэнтийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргаан /Б.Хашмаргад/-д тус тус даалгасугай.

4. Нэгдсэн арга хэмжээний явцад хяналт тавьж, үе шат бүрийн үр дүнг Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, удирдлага зохион байгуулалт, мэргэжил аргагүйгээр хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Ж.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ